

Дундговь аймгийн Засаг даргын Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдтай 2023 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 13

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Хууль эрх зүйн хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 30 үүргийг хүлээж, үүргийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажилласнаар жилийн эцсийн хэрэгжилт 94 хувьтай хэрэгжүүлсэн байна. Үүнээс 100 хувь-28, 70 хувь -1, 50 хувь-1, 0 хувь-1 байна.

Гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд нийт 653.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс Улсын төсвөөс 100.0 сая, Орон нутгийн төсөв 534.8 сая, байгууллагын төсөв 3.2 сая, төсөл хөтөлбөрөөс 6.6 сая төгрөг байна.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн төвийн ерөнхий боловсролын 4 сургууль, сумдын багийн иргэдийн өдөрлөг болон томоохон худалдааны төвүүдэд ажиллаж 4 G төхөөрөмжийг суурилуулж, Тоон гарын үсгийг 16174 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 2869 иргэнд гар утасны

gsign апплейшнаар дамжуулан олгосноор аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос 19042 иргэн буюу 59,5 хувьд олгож өмнөх оноос 12 хувиар ахисан.



Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон “Тогтвортой амьжиргаа-3” төсөлтэй хамтран “Хууль тогтоомж сурталчлах өдөрлөг”-ийг Өндөршил, Гурвансайхан, Адаацаг, Дэрэн, Баянжаргалан, Сайнцагаан сумдад зохион байгуулан 350 гаруй иргэд, “Хуульчийн Про боно” сурталчилгаа өдөрлөгийг аймгийн төвд мэргэжлийн 15 байгууллага оролцож 430 гаруй иргэд, олон нийтэд хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж, мэдээ мэдээллийг хүргэн ажилласан ба хууль зүйн сургалт, сурталчилгааг 6 суманд зохион байгуулж, нийт 780 гаруй иргэд сургалт сурталчилгаанд хамрагдсан. Сургалтад хамрагдсан иргэдийн тоо урд оноос 280 -аар ахисан нь иргэдийн оролцоо нэмэгдэж байгааг харуулж байна.




Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх зорилгоор 14 төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж арга хэмжээнүүдийн хүрээнд 75 зорилтот бүлгийн айл өрхөөр хяналт шалгалт хийж, 385 иргэнд 10 төрлийн 1800 ширхэг зурагт сэрэмжлүүлэг хүргэсэн.




Дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар энэ оны 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 8 бүртгэгдсэн ба урьд оны мөн үетэй харьцуулахад 11 нэгж буюу 57.9 хувиар буурсан эерэг үзүүлэлтэй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг



Аймгийн ГХУСАЗСЗ, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудтай хамтран “АРХИГҮЙ АМЬДРАЛЫГ ЦОГЦЛООЁ” аяныг зохион байгуулж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг “Говийн хийморь” АА бүлгэмтэй хамтран ажиллаж давхардсан тоогоор 482 хүнд эрхэмлэвэл зохих эрхэм дадал, эрүүл амьдралын зөв дадал хэвшил төлөвшүүлэх зөвлөмж, мэдээллийг өгсөн. Сogтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 74 бүртгэгдсэн нь өмнө оны мөн үеэс 9 нэгжээр буюу 10,8 хувиар буурсан.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг



Мал хулгайлах гэмт хэрэг 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 2 бүртгэгдсэн нь өмнө оны мөн үеэс 9 нэгжээр буюу 81,8 хувиар буурсан ба хэргийн илрүүлэлт 100 хувьтай байна.



Аймгийн Засаг даргын 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/259 дүгээр захирамжаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйлдэгдэж буй гэмт хэргийг шуурхай илрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгж, байгууллагуудад MNS6423:2019 стандартын шаардлага хангасан камерыг дотор болон гадна орчинд байрлуулах, гадна камерыг нийтийн эзэмшлийн зам талбайг 50 метр хүртэл хянах боломжтойгоор байрлуулахыг тусгасан ба одоогоор 136 аж ахуйн нэгж, байгууллагын 213 хяналтын камер ажиллаж байна. Өлзийт сум орон нутгийн хөгжлийн сангийн 17,0 сая төгрөгийн хөрөнгөөр 360 градус эргэдэг 4 ш камерын ажлыг хийж гүйцэтгэн хяналтын системийг тус сумын цагдаагийн хэсэгт байршуулсан. Эрдэнэдалай сум 2, Гурвансайхан сум орон нутгийн хөгжлийн сангийн 20,0 сая төгрөгийн хөрөнгөөр 49, Говь-угтаал сум 5, Луус сум 2 нийт 62 камер шинээр суурилуулсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 16 дугаар хуралдаанаар 2024 онд орон нутгийн төсвийн 939,0 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн төвийг камержуулахаар шийдвэрлэсэн.



ДЭГДЭЛЭН АЖИЛЛАЖ АХУЙН ХӨГЖ БИЛГЭЭНИЙ АЖ АХУЙН ТАЛГААР ТАШИЛЦУУГА

Аймаг / сумд	Цагдаагийн газрын аж ахуйн нэгж	Галдны хэмжээ	Дэргэдэн хэмжээ	Хөдөлгөөний хэмжээ	Цагдаагийн хөдөлгөөний хэмжээ	Цагдаагийн хөдөлгөөний хэмжээ	Хөдөлгөөний аж ахуйн нэгж	ИТ хэмжээ	Ажиллагсдын хэмжээ	МАН-ын хөдөлгөөний хэмжээ
	65	44	240	284	52	232	13	52	0	47
Аймагийн төв	28	53	129	182	155	27	2	155	27	12
	20	30	105	130	80	85	0	50	80	7
	25	47	104	150	70	80	2	70	80	14
Ардсүх	10	30	200	327	103	226	0	103	226	9
Д.Сүхбаатар	22	27	87	109	12	81	0	29	80	22
Д.Сүхбаатар	9	7	7	14	2	12	0	2	12	0
Д.Сүхбаатар	11	42	30	47	13	34	1	13	34	0
Д.Сүхбаатар	20	11	88	102	48	61	3	48	61	9
Д.Сүхбаатар	14	25	54	79	54	26	3	54	79	14
Д.Сүхбаатар	7	4	4	8	5	3	3	3	3	5
Д.Сүхбаатар	24	37	64	94	70	24	3	70	94	17
Д.Сүхбаатар	15	23	67	100	29	80	2	29	80	15
Д.Сүхбаатар	10	8	18	25	18	8	0	18	25	17
Д.Сүхбаатар	9	13	22	32	7	16	3	7	16	4
Д.Сүхбаатар	15	31	45	65	18	24	14	18	24	15
Д.Сүхбаатар	10	28	45	73	65	8	4	65	73	10
Д.Сүхбаатар	14	53	104	150	89	81	2	89	81	11
Д.Сүхбаатар	23	10	30	48	29	28	1	28	28	27
Д.Сүхбаатар	267	498	1557	2008	533	1137	65	706	547	279

Сумдад ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үүднээс Хулд сумын Засаг даргын Тамгын газар 25 сая төгрөгийн автомашин, Говь-Угтаал сум 3,8 сая төгрөгийн мотоцикл, аймгийн Засаг даргаас Луус, Эрдэнэдалай сумын цагдаагийн хэсгийн албаны тээврийн хэрэгслийн засварын зардалд 5,4 сая, ажилчдын байрны дээврийн зардалд 3,3 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Цагдаагийн кабоны халаалтын болон бусад зардал, тоног төхөөрөмжид орон нутгийн төсвөөс 80,1 сая төгрөгийг шийдвэрлэсэн байна.



Алба хаагчдыг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулж аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу 2023 онд алба хаагчдад тодорхой тооны радио станц, энгэрийн камер авах 10 сая төгрөг шийдвэрлэсэн. Цагдаагийн газрын нийт алба хаагчдын 42 хувь нь богино долгионы радио станцаар хангагдсан. Сайнцагаан сумын ГХУСАЗСЗ-өөс 6.3 сая төгрөгөөр гар станц 8 ш, согтуурал хэмжигч багаж 1, таблет 2 ш-ийг шийдвэрлэсэн.



Төрийн архивын баримт бичгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор 13,200,000 сая төгрөгийн үнэ бүхий 32 ширхэг нягтруулсан шүүгээ, 1 дүгээр хадгаламжийн сангийн гадна хаалганд 400,000 мянган төгрөгийн ухаалга цоожийг суурилуулсан. Архивын тасгийн ажилчдыг ажиллах нөхцөл боломжоор хангах үүднээс хурдын скайнер, ширээний компьютер, баримт зөөх тэргэнцэр, АЗ-ийн олон үйлдэлт канон зэрэг нийт 11,790,000 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжөөр хангаснаар нийт тоног төхөөрөмжийн 90 хувийг хангаад байна.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 94 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Хэрэгжилт удаашралтай болон тасарсан арга хэмжээнүүд

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Тасарсан болон удаашралтай байгаа шалтгаан
1	Хуульт ёс, дэг журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, чөлөөг хамгаалахад цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг бэхжүүлэх, нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, зам, талбай, олон нийтийн	Тус аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2023 онд ажиллах олон нийтийн цагдаагийн тоог 6 байхаар тогтоосон ба тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа 2 олон нийтийн цагдааг цагдаагийн алба хаагчийн сонгон шалгаруулалтад хамруулж, ахлагч бүрэлдэхүүнд дэвшүүлэн томилуулсан. Мөн 2 олон нийтийн цагдаа хүсэлтээрээ чөлөөлөгдсөн ба одоогоор тус аймгийн хэмжээнд олон нийтийн цагдаа ажиллаагүй ба олон нийтийн цагдаагийн сонгон шалгаруулалтын зарыг тогтмол явуулж байгаа боловч цалин урамшуулал	Ажлын байрны зарыг удаа дараа тавьсан боловч орох хүсэлтэй иргэн гараагүй. Энэ нь олон нийтийн цагдаагийн урамшуулал бага учраас бүртгүүлэхгүй байна.

	газруудад камерын хяналтын систем нэвтрүүлэх	бага байгаагаас шалтгаалан иргэд ажиллах сонирхолгүй бүртгүүлэхгүй байна.	
2	Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй ус хангамжийн эх үүсвэрийг орон нутгийн санхүүжилттэй гэрээт хамгаалалтад авах	Тус аймгийн төвийн ундны цэвэр ус хангамжийн эх үүсвэр буюу ус нөөцлөх 2 сан /резурвар/-г улсын онц чухал объектын жагсаалтад оруулж, төрийн тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын хамгаалалтад авах шаардлагатай талаар Цагдаагийн ерөнхий газарт удаа дараа хөрөнгийн судалгааг гаргаж хүсэлт хүргүүлсэн боловч тодорхой арга хэмжээ авч, ахиц гараагүй.	Аймгуудын ундны усны хангамжийн эх үүсвэрийг дотоодын цэргийн хамгаалалтад авах асуудал улсын хэмжээнд төлөвлөгдөж, яригдаж байгаа боловч энэ оны хувьд дээд шатны байгууллага, албан тушаалтнаас ямар нэгэн шийдвэр гараагүй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон төрөлт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулснаар тухайн төрлийн гэмт хэрэг урд оны мөн үетэй харьцуулахад буурсан эерэг үзүүлэлт байна.

Цагдаагийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх зэрэг арга хэмжээнд нийт зарцуулсан төсвийн 81.7 хувийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн нь гэрээгээр хүлээх үүргийн хэрэгжилтэд чухал нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Хууль эрх зүйн хэлтэст:

1.Тайланг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу хүрэх түвшинд хүрсэн эсэхийг тайлагнахаас гадна үр дүн, үр нөлөөний талаар тайлагнаж хэвших мөн нотлох баримтыг тайланд хавсаргаж байх


2.Дараа оны гэрээний төсөлд төсөв хөрөнгө нь тодорхой, үр дүн гарахуйц бодитой ажлуудыг тусгах саналыг яам руу уламжлах

3. Олон нийтийн цагдаагийн цалин хөлсний хэмжээг нэмэгдүүлэх ажлыг орон нутгийн түвшинд судалж холбогдох арга хэмжээ авах

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга  Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга  Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн ахлах мэргэжилтэн 

Э.Одончимэг